

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн нь 1968 онд "Ази, Африк судлалын хэлтэс" нэртэйгээр анх үүсэн байгуулагдаж, судалгаа шинжилгээний ажил тухайн үеийн гадаад дотоод бодлого, олон улсын харилцааны чиг хандлагатай уялдан орос, хятад судлалыг голлож байсны зэрэгцээ Ц.Хандсүрэн, Д.Дүнгэр-Яйчил, Б.Түмэнжаргал нарын япон хэлтэй түүхч, япон судлаачид эрдэмтэд ажиллаж, хүрээлэнгийн япон судлалыг эхлүүлсэн түүхтэй. Тэр үеэс хойш өнөөдрийг хүртэл Япон судлал хүрээлэнгийн судалгааны ажлын нэгэн гол чиглэл болсоор ирлээ.

1970-1980-аад онд Дорно дахин судлалын хүрээлэнд анхааран судалж байсан гол сэдвүүдийн нэг нь Япон улс дахь Монгол судлал байлаа. Хүрээлэн япон хэлтэй боловсон хүчнийг хуучин ЗХУ-д бэлтгэхийн зэрэгцээ Монгол Улсын Их сургуульд 1975 оноос япон хэлний сургалт явуулж эхэлсэн нь хүрээлэнгийн япон судлаачдын эгнээг өргөтгөхөд ач холбогдлоо өгсөн байна. 1980-аад оны үед Дорно дахины судлалын хүрээлэнг япон хэлтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, залуу судлаачдыг мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар ихээхэн анхаарал тавьж, япон хэлтэй залуучуудаа Япон улсад суралцуулж байсан нь Япон судлал өргөжихөд нөлөөлсөн билээ. Мөн судлаачдын санаачилгаар Дорно дахины судлалын хүрээлэнгийн дэргэд 1989 онд Япон судлалын төв байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн нь манай улсад япон судлалын чиглэлийн анхны төрийн бус, олон нийтийн байгууллага болж байв.

Дорно дахины судлалын хүрээлэн 1991 онд Зүүн хойд Ази судлал болон Дорно дахины судлалын чиглэлээр хоёр байгууллага болж салсан ч аль алинд нь япон судлалын ажил явагдан үр дүнд нь "Зүүн хойд Ази судлал", "Дорно дахины судлалын асуудал", "Дорно-Өрнө" сэтгүүлүүд нийтийн хүртээл болж байлаа. Дээрх сэтгүүлүүд нь 1990-ээд он хүртэл Азийн улс оронтой холбоотой судалгааны материал нийтэлдэг цорын ганц мэргэжлийн хэвлэл байв. Өөрөөр хэлбэл, 1990 оноос өмнө тус хүрээлэнд явагдаж байсан япон судлалын ажил төдийгүй манай улсын япон судлалын ерөнхий дүр төрх, чиг хандлагыг "Зүүн хойд Ази судлал", "Дорно дахины судлалын асуудал" сэтгүүлийн агуулгаас тус тус харж болохоор байдаг.

1999 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи япон судлалд онцгой анхаарал тавьж Олон улс судлалын хүрээлэнгийн шинэ зохион байгуулалтаар энэ ажлыг гүйцэтгэх шинжилгээ судалгааны бие даасан

нэгж болох Япон судлалын секторыг шинээр зохион байгуулж ажиллуулах болсон билээ. Энэ нь тус хүрээлэнгийн япон судлалын уламжлалыг бататгаж, уг судалгааг өргөтгөн урагш ахиулахад чиглэсэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Эдүгээ Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлал уламжлалт судалгааг гүнзгийрүүлэхийн хамт манай улсын эдийн засаг, нийгмийн байдал, хөгжлийн зорилт, чиг бодлоготой уялдуулан Япон Улсын хүчин зүйлийг тодруулан судлах, хоёр орны харилцааны түүхэн хөгжил, манай улсын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн талаас нь анхаарал хандуулж, Японы улс төр, эдийн засгийн бодлого, бүтцийн өөрчлөлт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөгжлийн туршлагыг гүнзгийрүүлэн судлах, хүрээлэнг Япон судлалын боловсон хүчнээр бэхжүүлэх, хоёр ард түмний харилцан ойлголцол, итгэлцэл, найрсаг харилцааг гүнзгийрүүлэх, Япон Улстай тогтоосон бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэхэд тус дэм үзүүлэх зорилт тавин ажиллаж байна. Тухайлан Монгол Улс, Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагааны боломжид эрэл хайгуул хийх, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд судалгааны үр дүнгээр тус дөхөм үзүүлэх зорилгоор "Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг" (2021-2023 он) судалгааны ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны хагас зуун жилийн түүхэн ой энэ 2022 онд тохиож байгаатай холбогдуулан Монгол, Японы харилцааны түүхэнд анх удаа хоёр орны хагас зууны харилцааны хөгжил дэвшлийг илэрхийлсэн баялаг түүхэн үйл явдлуудыг гэрчлэх албан ёсны баримт бичгүүд болох "Монгол, Японы харилцаа: Он дарааллын товчоон 1972-2022" (УБ., 2022), "Монгол, Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022" (УБ., 2022) эмхэтгэлийг нийтийн хүртээл болголоо. Мөн сүүлийн жилүүдэд суурь судалгааны үр дүнд тулгуурлан Япон судлал, Монгол-Японы харилцааны чиглэлээр олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний олон хурлыг амжилттай зохион байгуулсаар ирлээ.

Үүнээс онцлон тэмдэглэхэд манай хүрээлэн 2000 оноос хойш жил бүр уламжлал болгон явуулж байсан "Олон улс судлал" эрдэм шинжилгээний хурлаа сэргээх, чингэхдээ Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд "Олон улс судлал: Монголын Япон судлал" сэдвээр 2022 онд зохион байгуулахаар төлөвлөж амжилттай хэрэгжүүлсэн болно.

"Олон улс судлал 2022: Монголын Япон судлал" эрдэм шинжилгээний хуралд Япон судлал бүхий Монгол Улсын шинжлэх ухааны голлох байгууллагууд болох Монгол Улсын Их сургуулийн Ази судлалын тэнхим,

Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн ОУХНСС, ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, стратегийн хүрээлэн, Зэвсэгт хүчний 311-р ангийн удирдлага, Япон судлалын чиглэлээр дагнан судалгаа хийдэг судлаач эрдэмтэн багш нарын төлөөлөл оролцлоо.

Тус хуралд оролцсон эрдэмтэд Япон Улсын улс төр, гадаад бодлого, аюулгүй байдал, эдийн засаг, шашин, гүн ухаан, Монгол-Японы харилцаа, түүх, улс төр, эдийн засаг болон шинжлэх ухаан, боловсролын харилцаа гэсэн ерөнхий дөрвөн чиглэлийн хүрээнд 10 гаруй илтгэл тавьж, хэлэлцүүлэг зохион байгуулсныг бид бүрнээр эмхэтгэн гаргаж байна.

“Олон улс судлал 2022: Монголын Япон судлал” эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улсад Япон судлалыг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх хүрээнд эрдэмтэн судлаачид судалгааны үнэтэй санал, дүгнэлт дэвшүүлж, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэн мэдээлэл солилцсон үр дүнтэй эрдмийн арга хэмжээ болсныг энд онцлон тэмдэглэе.

Энэхүү эмхэтгэлд тусгасан эрдэмтдийн судалгааны санал дүгнэлт нь хувь судлаачдын байр суурь бөгөөд Монголын Япон орон судлалын нэгэн үеийн хөгжлийн түвшнийг илтгэн харуулахуйц бүтээлүүд багтсан болохыг онцолж байна. Цаашид тус хүрээлэнгээс “Олон улс судлал” эрдэм шинжилгээний хурлыг жил бүр орон судлалын тодорхой чиглэлд хандуулан тогтмолжуулан зохион байгуулж байхаар төлөвлөж байгаагаа Та бүхэнд дуулгахдаа таатай байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын салбарын эрдэмтэн судлаачид голлох үүрэгтэй оролцсон болно. Энэ дашрамд тус эрдэм шинжилгээний хурлыг санаачлан удирдлагаар хангаж ажилласан хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Д.Золбоо, илтгэлээ хэлэлцүүлсэн болон хурлын үйл ажиллагаанд үг хэлж дэмжиж оролцсон нийт эрдэмтэн судлаачид, эмхэтгэн хэвлүүлэх ажлыг хариуцан ажилласан эрдэм шинжилгээний ажилтан Б.Саранчимэг, А.Сосорбурам хянан нягталсан У.Загдцэсэм, Ш.Догмийчойдон болон “Соёмбо принтинг” хэвлэлийн газрын хамт олонд гүн талархлаа илэрхийлж байна.

Монголын олон улс судлал бадран хөгжиж, эрдэм бүтээл ундарч байх болтугай.

*Шинжлэх Ухааны Академийн  
Олон улс судлалын хүрээлэнгийн  
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
доктор Раднаасэдийн ТӨРДАЛАЙ*